



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 115

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Эрчим хүчний төсөл-2”-ын хүрээнд нийлүүлсэн нийт 371,789,064.96 (гурван зуун далан нэгэн сая долоон зуун наян есөн мянга жаран дөрвөн төгрөг ерэн зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Н.Тавинбэх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАНБАТ

А.АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2019 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн
145... дугаар тогтоолын хавсралт

**"Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн
үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалт**

/Монгол банкны 2018.11.29-ны өдрийн ханш 1\$=2605.84/

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ /ам.доллар/	Балансын үнэ /ам.доллар/	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Балансын үнэ /төгрөг/
1	Суурин компьютер	ш	1	2,163.00	2,163.00	5,636,431.92	5,636,431.92
2	Суурин компьютер	ш	63	901.00	56,763.00	2,347,861.84	147,915,295.92
3	Зөөврийн компьютер	ш	4	1,235.00	4,940.00	3,218,212.40	12,872,849.60
4	Өнгөт принтер /A4/	ш	1	488.00	488.00	1,271,649.92	1,271,649.92
5	Галт ханын төхөөрөмж /Firewall/	ш	1	3,390.00	3,390.00	8,833,797.60	8,833,797.60
6	Галт ханын төхөөрөмж /Firewall/	ш	1	7,850.00	7,850.00	20,455,844.00	20,455,844.00
7	Зургийн аппарат	ш	1	3,300.00	3,300.00	8,599,272.00	8,599,272.00
8	Тог баригч	ш	1	8,244.00	8,244.00	21,482,544.96	21,482,544.96
9	Үйлдлийн систем	ш	1	843.00	843.00	2,196,723.12	2,196,723.12
10	Хэвлэгч машин /A4/	ш	7	466.00	3,262.00	1,214,321.44	8,500,250.08
11	Мэдээллийн сан ба Веб сервер	ш	6	2,693.00	16,158.00	7,017,527.12	42,105,162.72
12	Серверийн дагалдах	ш	2	1,330.00	2,660.00	3,465,767.20	6,931,534.40
13	Киоск	ш	7	927.00	6,489.00	2,415,613.68	16,909,295.76
14	Үйлдлийн систем Виндовс	ш	1	104.00	104.00	271,007.36	271,007.36
15	Суурин компьютер	ш	1	921.00	921.00	2,399,978.64	2,399,978.64
16	Принтер /A3/	ш	1	1,685.00	1,685.00	4,390,840.40	4,390,840.40
17	Мэдээллийн сангийн сервер	ш	2	4,100.00	8,200.00	10,683,944.00	21,367,888.00

6098169 1118262983

Д/д	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ /ам.доллар/	Балансын үнэ /ам.доллар/	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Балансын үнэ /төгрөг/
18	Сүлжээний свич холбогч	ш	2	953.00	1,906.00	2,483,365.52	4,966,731.04
19	Дуу хураагч	ш	1	48.00	48.00	125,080.32	125,080.32
20	Электрон мэдрэгчтэй самбар	ш	1	13,080.00	13,080.00	34,084,387.20	34,084,387.20
	Нийт дүн		106	54,721.00 \$	142,494.00 \$	143,066,670.64 (нэг зуун дөчин гурван сая жаран зургаан мянга зургаан зуун далан төгрөг жаран дөрвөн мөнгө)	371,789,064.96 (гурван зуун далан нэгэн сая долоон зуун наян есөн мянга жаран дөрвөн төгрөг ерэн зургаан мөнгө)